

CONTEMPORARY ART – МОНГОЛЫН УРЛАГИЙН ИРЭЭДҮЙ ...

Ч. Болдбаатар *

Олон улсад поп урлаг бүрэлдэн тогтноход нөлөөгөө үзүүлсэн түүхэн баримтын гэрчүүд бол уг өгүүллийн гол цөм нь юм. 1990-ээд оны дундаас бид, орчин цагийн сэтгэлгээ хаашаа “салхилж” чиглэгдсэнийг төдийгүй ready-made, assemblage, combine-art зэрэг эвлүүлэг-зүүлт бүр холимог ажилбарын ярианд шилжсэнийг хэлэлцүүлж байна.

Ямар боловч, одоогийн энэ цаг дор contemporary art л анхаарлын төвд байгаа билээ. Энд уран зураг хийгээд уран баримал гэсэн төрөлсөл хашилтанд авагдаж, тэдгээрээс илүүтэй урлагийн задлал шинжлэл, шүүмж рүү санаа тавьснаар “анти-дүр” бүхий ажлуудын заримаас тайлбарлахад хүрснээ хэлэх юун.

Дэлхийн хоёрдугаар дайны дараагаар урлаг эрчтэй өөрчлөгдөх зайлшгүй нөхцөлийг имидж тодорхойлох болжээ. Иймээс аккумуляцичилах үйл явц өрнөж, бүтээлч хэн гэдгээ таниулахаас гадна үйлдлээ чөлөөлөх байдлаар өөр бусдыг өдөөх нээлттэй харилцааг зөвхөн үзүүлбэрлэхэд чиглэсэн байна. Болзмол хэрэглээг энгийн эдээр хүртэл орлуулах захгүй эрэлт ч үүнтэй уялдаж, улмаар нийтээрээ таашаах соёлын хүрээг тэлсэн нь үнэн. Тэгвэл дадачууд өдөр тутмын хэрэглээний эд зориулалтыг эвдэхийг урьтал болголтгүй тавигдах шаардлагаа сөргүүлээд сэтгэл зовинолоос зай барих, уйгаа чөлөөлөх актаар солих ёстойг илтгэхийн сацуу эргэлзэх совингоо санаанд оромгүй хэсэгчилсэн эвлүүлэг мэт харуулчихдаг аж. Тэд үүнийгээ урлаг амьдрал хоёрын заагийг арилгах хэрэгсэл гээд, цаашлаад алив бүтээсэн бүхэн автороо илэрхийлэх албагүйг мөрдлөгөө болгосноо зарлачихав. Тодорхой хэлбэл, коллажийн аргад автор хөндлөнгийн оролцогч байна гэсэн үг л дээ. Гэхдээ коллаж хийгээд “анти-урлаг”¹⁾ нь зөвхөн гоо сайхны шалгуурын няцаалт байсан гэж тулгаад ойлгох хэрэггүй биз. Юутай содон хачин имитаци байлаа, тухайн орлуулалт бүхий ажил уншигдах интерпретацитай байж л эвлүүлмэл хэл хэллэгээ олж таарна. Чухамдаа интерпретацичлал гэх үг дан ганц тайлал төдийг заадаггүй. Тэрхүү томъёолол ухагдах комбинациасаа шалтгаалаад ондоо гаргалгыг төлөөлдөг ч явдал бий. Имитаци өөрөө таагдашгүй имиджээр солигдвол үйлдлийн оролцоот репрезентаци оньсого байх магадлалтай.

* МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Урлаг судлалын тэнхим

¹⁾ Модернизм-анализ и критика основных направлений. М., 1987, с. 190-191

Үүний хариулт гэвэл, Марсель Дюшаны “Өрөөсөн дугуй” (1913) ready-made² л даа. Магадтай нь, унадаг дугуйн өрөөснийг сандалд бэхэлж тогтоосонд үзэгдэх гойд юм алга ч харин хэлэхийг хүссэн интерпретациараа “Юу ч биш” гэх нигилист мэтгэлцээнд зориуд түлхэж буй нь сонин. Үнэндээ Дюшан өөрөө нигилизмын ертөнцөөр амьсгалдаг этгээд байв. Тиймээс л өөрийнх нь үзүүлэхээр оролддог “Юу ч биш” гэдэгтээ орчлонгийн хий, оргүй хоосныг илэрхийлэхийг завдадгүй, зөвхөн хэний ч төсөөлж харж чадахааргүй “агуулгагүй” эд юмсын бөөгнөрөл байдгийг олоод үзээч !!! гэх шиг. “Том шил” (1915-23) хэмээх инстоляцийн гүйцэтгэл ч ялгаагүй хачин этгээд интерпретацийн өдөөлтэйг гайхах хэрэггүй шүү. Тус ажилд “бүтэн биш” ч уншивар бий: “Гоонь эрчүүдийн нөмгөлсөн сүйт бүсгүй, тэр ч байтугай” хэмээдэг л дээ. Этгээд эл уншварыг хүртэхийн тулд “инстоляц”-ийн хэлд боловсрохоос өөр ямар ч аргагүй болох нь. Тийм ээ, contemporary урлаг руу дөтлөхийн тулд өөрийгөө хууралгүй зохих ном дэгийг унших цаг хэдийнээ болжээ. “Болжээ” хэмээх нь утгаа постпостфилософийн яриаг тодорхой хэллэгээр нь ойлгохыг хэлээд байгаа хэрэг. Дюшанаас үүдэлтэй эвлүүлгийн хэлийг installation үгүйгээр, combine үгүйгээр, assemblage үгүйгээр ухахын аргагүй, үүнийг хүлээж авч эс чадвал нийгэм өөрийнхөө оюун санааны ололтод итгэхээ болиход хүрч болзошгүй...

Нэгэнт хэрэглээний эдийн сонголттой зэрэгцээд концептуалиар сэтгэх хандлага хавсрагдан тайлбарлагдаж байгаа болохоор “холимог ажилбар” (mexid) болон “эвлүүлэг зураг” (combine paintings)-ын талаар үргэлжлүүлээд тодотгох нь зүйтэй байх. Чухамдаа урлагийн төрөл зүйлийн ангилал хэт явцуурснаар хэллэг нь зогсонго байдалд орсон нь бас үнэн. Холимог ажилбарыг олон бүтээлчид өөр өөрийнхөө эрэл туршилтаар нөхөж улам сонирхолтой техникийг нээж буйг би хувьдаа жанрчилал задарснаас үүдэлтэй гэж ойлгодог. Нарийндаа бидний mexid гэж нэрлээд байгаад томъёолол бол дадагаас эхтэй ч сюрреалистуудын бүтээлд яах ч аргагүй хэрэглэгдээд заншсан frottage (хусалт), decollage (ховлолт), fumage (уталт-түлэлт) мэтийн техниктэй шууд холбогдоно. Эндээс л “зурах”, “барих” гэх ойлголтууд синтезчилэгдээд зогссонгүй кодлох явцаас кодлохоо болиход (тэмдэг үгүй) үйлдэлшсэн харилцааны “бөөгнөрөл” (assemblage)-рүү орчихсон түүх эхэлдэг. Өөрөөр бол комбинацийн бүрэлдэл түүвэрлэлт-сонголт юм.

Ямар нэгэн улсын далбаа, хил хязгаарыг тэмдэглэсэн газрын зураг, тэр бүү хэл буудлагын бай, халбага, шүүр, сэрээ, шүдний сойз, чийдэн, шар айрагны лаазыг гайхагдам эвлүүлэгийн өгөгдөл болгочихсон аугаа комбинатор ч байна. Энэ бүхэн Джаспер Джонсын нэртэй холбогдоно. Джонсын ашигладаг дармалдсан үсэг тоо гэхэд ямар ч утга агуулдаггүй шигээ зохиомж нэхдэггүйгээрээ тун содон. 1954 он бол түүний хувьд жинхэнэ аз заяасан учрал болж тэмдэглэгддэг. “Монограмм” (1955-1959) хэмээх цувралыг бүтээлч Роберт Раушенберг, нөгөөх “анир үгүй” паузын давталтаар “4’33” хэмээх “роп” хөгжим бичсэн Джон Кейж нар 1954 оноос Джонстой үзэхүйгээрээ анд болоод зогссонгүй нийлээд Америкийн урлагийг дэлхийд таниулахад ихээхэн үүрэг хувь нэмрээ оруулсан төлөөлөгчид юм. Тэрээр өөрийнхөө хийснийг тайлбарлахдаа: “миний бодоход чухам объект гэх ойлголт тун эргэлзээтэй, хоосон зотон ч будаг ч тэр объект болж мэднэ. Яагаад гэвэл зотон байгаараа яалт ч үгүй орон зайг төлөөлөөд буй биш үү”³ хэмээсэн нь нэгийг бодогдуулна. Кунингийн түүнд санамсаргүй санаа өгсөн наргианыг энд зориуд дурьдмаар байна. Нэгэнтээ түүнд “Чи яагаад Ле Кастеллид наад

²) 50 ans d’art moderne. B., 1958.

³) Idea and image recent art. Chicago. 1979, p. 15

шар айрагны хоосон бортогоо санал болгож болохгүй гэж? хэмээсэн гэдэг. Тэр даруйд имитация арай томсгоод хүрлээр цутгасан “Хос лааз” (1960) санал болгоход шаггүй үнээр худалдаад авсан байдаг. Ингээд эргэцүүлэхэд, поп урлагийн критик Лоуренс Оллоуэйгийн хэлсэнчлэн “арилжааны соёлын эгдүүцэл ч...эцсийн дүндээ цэнгэх, цэвэр уйтгар сэргээлт, эскапизи мэт үгсийн заагт нийтийн соёл хэрхэн илэрдгийг... хий мэтгэлзэлгүй нэг тийш шийдэх ёстой болжээ”⁴ хэмээсэн нь хэн юу дуртайгаа хий гэсэн үг биш болой. Тэгээд ч шүүмжлэгчдийн мэтгэлздэг ухагдахууны гаргалга, “олон-соёл”-ын тухайд өөрсдөд нь харгалзвал зохих хариуцлага ноогдсоноо үүрэх арга зам хэрэгтэй гэсэн Лоуренс Оллоуэйгийн санаа зөв л дөө. Эд юмс урлаг хоёрын хамтдаа нийлэгшиж эхэлсэн ойртолт цааш үргэлжлэх болно гэдэгт эргэлзэх хэрэггүй ч байж мэднэ. Одоо цагт, байгаа бэлэн зүйлийг имитациар орлуулдаг практик өргөн дэлгэрч сонирхолтой үр дүнд хүрч байна. Поп урлагийн баримжаа яг л моодны нэгэн адил өөрчлөгддөгийг уран сайхны бус ололтууд нэг бус удаа баталлаа. Яалт ч үгүй хүлээн зөвшөөрөгдөөд буй олон “Комбинаторууд”, тэр тусмаа тэдний чиглүүлсэн урсгалыг судлаачид баттай тайлж чадахгүйг үгүйсгэх аргагүй. Моодны зураачдын хэлсэн ярьсан бүхнийг дэмий дурьдахаас, харин юу гэж тайлбарласныг зориуд авч үзвэл зохилтой нь мэдээж. Ирээдүйд хэрхэхийг, чухам урлагийн хэл хэллэг ямар шийдэлд хүрэхийг хэн ч эс мэднэ. Тэгэхдээ урлаг нэг чиглэлээр урагшлахад нөгөө талаар зогсонго байдалд ордог тул дан ганц үсрэлт гэж байхгүйг л би хувьдаа мэдэрч байна. Попчуудын эрмэлзэж тэмүүлж ирсэн бүх зүйлд өөр өөрийн сонголт хайсан нээлтэй санаа байдаг нь анзаарагддаг. Иймээс, хэлсэнийг нь тус бүрээр эшилж дурдья.

Роберт Раушенберг: “Миний хувьд зурах гэдэг аливаа ухамсарласан манипуляци (төвөгтэй арга), эсвэл хяналттай байхаас илүүтэй бүтээх хэрэгсэлтэй ойртон, харилцан нөхцөлдсөн методыг үзүүлэх ёстой”⁵ гээд, цааш үргэлжлүүлэн: “...тохиолдол бүрт би итгэдэггүй шигээ бусад бүхий л аргад ялгаагүй итгэл алдарлаа. Миний хувьд гадаад ертөнцийн эгэлхэн элементүүдийг хүлээн авч аль болохоор тэдэнтэй нэгдэлд орох нь л чухал...”⁶ хэмээж,

Рой Лихтенштейн: “Пародии буюу элэглэхүйн цаанаас үгүйсгэлийн бичвэр зуучлагддаг. Миний ажил яг тэр биш л дээ. Гэвч муляж надад гайхагдам харагддаг шүү”⁷ гэсэн байхад,

Энди Уорхол: Америкаар л би амьсгалдаг, туурвил минь үүний тухай л юм. Миний гэсэн бүхэнтэй танилцахыг хүсвэл, Америкийг бүтээн босгогчдыг тэр чигт нь хүлээн авч, хувь хүмүүсийг афишийн давталт шиг объект болгон хувилгасан сүлдлэлийг олж харахыг бодоорой”...⁸ гэж,

Том Весселман: “Миний тэмүүлэлд аливаа сэтгэл хөдлөлийн харилцаа огтхон ч хамаагүй, ганцхан намайг уусгагч физикаль юмс л нэмэртэй. Улигшсан утга зохиолын ассоциацилиг элементүүдээс ангижрах нөр их зүтгэлийг би гаргаж байна. Миний үзэхэд зураг ч гэсэн гагцхүү биетийн оролцоо болоод нягтад тулж очихыг би хүснэм”⁹ гэж өгүүлснээс ойлгогдох байх. Эдгээрт дүгтэлт хийвэл мөнөөх анти-урлагийн тунхаг,

⁴) Lippard L.R. Pop art. With contributions by L.Alloway, N.Marmer, N.Calas. L., 1970. p. 32.

⁵) Tomkins C. The bride and the bachelors. Five masters of the avant-garde H., 1976. p. 204.

⁶) Мөн зохиолд, р. 231

⁷) Rublowsky J. Pop art. N-Y., 1965. p. 137.

⁸) Lippard L.R. Pop art. With contributions by Alloway, N. Marnet. N.Calas. L., p.87.

⁹) Alloway L.American pop art. N-Y-L., 1974, p. 109

анти-дүр байх-үгүйг эвлүүлэг ба ажилбарын хувьд хэрхэн шийдсэн тус тусын нээлт гэж үзэж болно.

Нью-Йоркийн Бронкс дүүрэгт бусдын дууны хэсгээс “сэмпл” буюу хэмнэлийн зарим тактыг түүвэрлээд чихруулан давтдаг хоолойн үзүүлбэр газар авч байсан лугаа Джон Кейджийн чимээг (chance) аягүй дуугаралтаар шилжүүлэх хандлага поп хөгжимд тархжээ. Үнэндээ өнөөгийн поп хөгжим “симпл” гэх аялгын хэсэгчлэлийг зүгээр ч нэг хэрэглэсэнгүй гагцхүү имитацичилал руу шилжүүлчихлээ. Тэгээд л эвлүүлгийн хувилбар нь барималд хүртэл ассембляж өдөөлтөөрөө хүрээгээ тэлэх болсон юм. Бас Жефф Кунсийн “Бөмбөгөн хав” (2000) хэмээх гялгар хуванцар эдээр үйлдвэрлэсэн ажлыг хөл хөгжөөнтэй гудамд зориуд хаясныг декор мэт хүртэж ойлгож байсан нь саяхан. Гэтэл энэ бүхний ард “бүтээх” арга цоо шинэ хэрэгслээр ухагдаж гагцхүү проектоо санаагаа тусгаад төсөл болгоод л үлдээчихдэг болчихжээ. Польшийн барималч Магдалена Абконович гэхэд “Бөөгнөрөл”-д (1995) холимог эдийг, ө.х., төмөр, шуудай, олс мэтийг хөндий цутгуурт хэрэглэсэн мөртөө үйлдсэн 250 зогсож буй фигураа огт толгой түрүүгүй орхижээ. Ингэж иностояциас илүүтэй эдийн “combine” үүсгэхийг оролдсон байж. Навч, мөчир, чулуу мэтийн хаа сайгүй тааралддаг хаягдлыг (хогийг) үзүүлбэр болгохдоо хажуугаас харахаар бус дамаа агаараас, хавьгүй өндөрлөгөөс мэдрэхээр чиглэгдснийг Францын Альпийн нуруунд босгосон “Манааны Шовгор” (2000) хэмээх Английн Энди Голдвортын ленд-артаас ойлгох боломжтой юм. Харин Дональд Жадд “Нэр үгүй” (1970) минималь ажлаараа “эгэл юмс урлагийг төлөөлөх ёсгүй гэж үү” хэмээх асуулт тавьж байхад, харин Аниш Капурын “Диваажингийн үүд” (1999-2005) гэхэд асар том хэмжээтэй эзэлхүүнт хуйлмал пластикаараа АНУ-ын Чикаго хотынхныг цочроогоод гайхшируулсан. Тус 10 метрийн өндөртэй толин гадаргад тэнгэр тэр чигтээ шахуу буучихаар тусагдахууныг имитацичилжээ. Үүгээр тогтохгүй хуванцар эдийг өөр хооронд нь технологийн дагуу холимогшуулж өрсөлдсөнөөр, бүтээгчид нь texture-ээр хүчээ сорих нь элбэгшив.

Гэтэл манайд 2013 онд Монголын бүтээлчид хатагтай Н.Оюунбатын санаачлага дор “Бенеттоны нэгдсэн өнгө” гэх уриалгыг нийтээрээ хүлээн авлаа. United Color of Benetton бренд манай оронд бүтээгдэхүүнээ дэлгэн харуулахын сацуу урлагийн олон хамтрагчтай нэгдсэн нь гайхалтай. Хамгийн гол нь, “Торгоны замын” эртний нүүдлийг санагдуулам илгээмжийг монголын өнөөгийн амьдралд нутагшуулах нь тэр. Тиймээ, Лучиано Бенеттоны нэрээр овоглогдсон галерей нь “Саахалт айлын аккумуляцийг” шингээхийг хүсчээ. Боломж ч биелэлээ олж анхны үзэсгэлэнд зориулсан бүтээлийн цомог хэвлэгдсэн байна. Миний ажигласнаар, эсгий туурагтны ахуйг дагалдаад үүссэн бичвэрүүд уг цомогт багтжээ. Номын чимэг, хавтас, хуудасны эвхэлтийг харахад Джаспер Джонс шиг зотонгийн ар өвөрийг зориуд мессеж болгон үзүүлжээ. Тэдгээрийн дотроос Бүдзагадын Нандин-Эрдэнэгийн “Нэр үгүй” хэмээх ажил нэлээдгүй сонирхол татсаныг хэлэх нь зүйтэй байх. Түүний ажилд төмөр чигжээст шүд, аниргүй уруул, цэв цэвэрээр үлдээсэн зотон, эргүүлж татсан формат хамтдаа тэмдэгшиж танигддаг. Гүйцэтгэлийн хувьд баналь хэллэгтэй нь поп урлагийн маягтай яг таг авссан гэмээр. Тухайлбал том, маш томоор тасалсан уруул л харагдана, бас 10x12 см хэмжээс... Түүний ажилд Малькольм Морлигийн оролдлоготой тун адил сул орхисон хоосон тайлбай цэлийгээд тусдаг.

Иймэрхүү дидакчилсан комбинацийн тоглол Гочоогийн Сэрээтэрийн “Торс ба Тусгал” (1998) хэмээх ажлаас харж болно. Ажил нь 1998 онд дэлгэсэн “Хөг” нэртэй бие даасан бүтээлийн цомогт бий. Тэр л ажлаараа рациональ сэдлийг гагцхүү хашилтанд

зөвшөөрөх ёстой гэсэн зарчмын үүдэл мэдрэгддэг гэх үү дээ. Тухайн цаг үед “нон-финито” буюу “төгс эс бүтэх” шийдлийг Г.Сэрээтэр шиг ойлгохыг хүссэн бүтээлч ховор байсан. Тэрбээр анх шил ба галбир, дүрс ба тусгал хоёрын комбинацийг, тэгэхдээ “торс”-ийг тэр чигт нь биш таллан хэсэгчилэн шилний наад цаадах сүлэлдээнд хуурмаг (a trompe l’oeil) тусгалаар үзүүлэхийг оролдсон байна. Шилээр заагласан хэсэг бусад диспозици төсөө нь ч байршлын хувьд нэг нь нөгөөгөө орлох мэт. Тийм сөөлжсөн таслалт, эцсийн дүндээ апсихоз. Ингээд л интенциаль агшин өөрөө нөхцлийн цэгээр дамжин зэрэгцэж эвлүүлэгдэх нь тэр. Зэрэгцлээ ялгаралтаар хавсаргах нь ч бас харагддаг. Нэг ёсондоо Джиль Делёзийн постструктуралист үзэхүйд яригддаг объектыг ялгаж ангилахад биш харин цуглуулж бөөгнүүлсэн зүйлээ объект болгох оролдлого тусч байж мэдэх юм. Тодруулбал түүний коллажид галбир ба тусгалын хэсэгчлэлийг өөр материалын эвлүүлгээр, өөр оронгийн заагаар нөхөлт болгон хувиргажээ. Сэрээтэрийн комбинаци ийм л хэллэгтэй. Хэдий ийм ч урлаг тодорхой цаг үед асуудлыг дэвшүүлэн тавьж, бас шийдвэрлэх тэр л үйл явцаар өрнөж ирсэнийг дээрх хэдэн жишээ харуулж баталлаа. Чухамдаа поп урлаг гэдэг ойлголт дотор нь ахиад огт дурдагдахгүй хэв маягийн үлэмж олон томъёолбор нэхэгддэгийг дуртай ч, дургуй ч үргэжлүүлэн судлахдаа нээгээд зогсохгүй дахин нээх шаардлага нэмэгдсээр буй. Эцэст хэлэхэд, монгол ахуй тэр чигтээ ассембляжийн хувилбарууд гэдгийг санахад илүүдэхгүй байх. Учир нь нүүдэлчид хар багаасаа чулуугаар наадаж тэдгээрээ адуу мал эсвээс авдар сав мэт төсөөлөн зугаацан харилцаж, яг л амьдрал дээрх шиг үйлдлийг имитациар давтдагийг мартахын аргагүй. Энэ чинь л өөрөө ассембляж бус уу.

РЕЗЮМЕ

Часто обсуждается, произведение искусства существовало в форме-произведения. Это означает, что оно будет находиться за пределами их предубеждений. Ready-made, performans art должна идти выше этого. То, есть формальные принципы можно понять или уже понятно. Это-что то, это ничто.